

ОРЧУУЛАГЧ Н.ДОРЖГОТОВ БА МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО

Д.Отгонтуяа¹⁶², Б.Нямжав¹⁶³

Товч утга: Энэхүү өгүүлэлд Монголын утга зохиол, яруу найраг, соёлын өвийг дэлхийд таниулах олон бүтээл туурвисан Хэл бичгийн ухааны доктор, орчуулагч Н.Доржготовын амьдрал, уран бүтээлийн тойм, түүний англи хэлнээ орчуулсан Монголын Нууц Товчоон дахь зарим хэцү хэллэгийн оновчтой орчуулгыг тодруулан авч үзсэн болно.

Түлхүүр үг: Н. Доржготовын амьдрал, уран бүтээл, Монголын Нууц Товчооны орчуулга, хэцү хэллэг, соёлын утга.

Монголын орчуулга судлал, орчуулгын уран зохиолд үнэтэй хувь нэмрээ оруулсан манай үе үеийн орчуулагчдын нэг бол Хэл бичгийн ухааны доктор, орчуулагч, багш агсан Н.Доржготов (1941-2014) юм. Тэрээр 1966 онд МУИС-ийн Гадаад хэл, утга зохиолын ангийг дүүргэн, 1966 онд Москвагийн Гадаад хэлний дээд сургууль, 1968-1969 онд Английн Лийдсийн их сургууль, 1996 онд Английн Делеварын Их сургуульд хэл, уран зохиолоор мэргэжил дээшлүүлжээ. 2003 онд “Орчуулгын хэлбэр, агуулгын шүтэлцээ” сэдвээр хэл бичгийн ухааны докторын зэрэг хамгаалсан юм. 1966-1976, 1980-1985 онуудад Нийгмийн Аюулаас Хамгаалах яаманд орчуулагч, 1976-1980 онд Хятадын Элчин сайдын яаманд Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн, 1985-1989 онд Гандан хийдэд зөвлөгч, 1989-2014 онд МУИС-д багшаар тус тус ажиллаж байжээ.

Н.Доржготов нь “Бурхан Буддагийн сургааль”, “3-р Далай ламын тунгаамал алт”, “14-р Далай Ламын Түвдийн Буддын ертөнц” зэрэг буддын гүн ухааны зохиолуудыг англи хэлнээс орчин цагийн монгол хэлнээ орчуулжээ. Мөн англи, америкийн уран зохиолын 80 гаруй өгүүлэл болон үлэмж тооны шүлгийг монгол хэлээр орчуулж олны хүртээл болгосон. 2005 онд Монголын зохиолчдын хорооны захиалгаар Монголын төрийн шагналт 20 гаруй найрагчийн 50 гаран шүлэг, зохиолыг англи хэлнээ орчуулсан нь Монголын соёл, утга зохиол, яруу найргийг дэлхийд таниулдаг “Гуну” /GUNU/ сэтгүүлд хэвлэгдэж хожмоо ном болон гарчээ.

1999 онд “Англи-Монгол, Монгол- Англи мал аж ахуйн дүймэн”, 2006 онд “Монгол-Англи буддын дүймэн”, 2007 онд “Англи Монгол утга зохиолын дүймэн” зэргийг тус тус зохиосон нь харьцуулсан судалгаа хийж байгаа оюутнуудад их тустай бүтээл болсон байна. 2006-2008 онд Монголчуудын хэл, түүх, соёлын үнэ цэнтэй, 13-р зууны монголын уран зохиолын гайхамшигт дурсгал болох “Монголын Нууц Товчоон” зохиолыг З.Эрэндоогийн хамт англи

¹⁶² МУИС-ийн ШУС-ийн Их Британи, Америк судлалын тэнхимийн багш, доктор /Ph.D/

¹⁶³ МУИС-ийн ШУС-ийн Их Британи, Америк судлалын тэнхимийн багш

хэлнээ орчуулсан нь гадаадын орчуулагчдын орчуулалгүй орхисон эсвээс галигчилсан үндэстний онцлог бүхий үг хэллэг, хэлцийг орчуулсанаараа онцлогтой болсон юм. 2010 онд Монгол тулгар төрийн 2220 жил, их эзэн Чингис хааны мэндэлсний 850 жил, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойд зориулан гаргасан “Монгол үндэстний биет бус соёлын өв” хэмээх томоохон бүтээлийг англи хэлнээ Ш.Номиндарь, У.Сайнбаяр нарын хамт орчуулсан төдийгүй орчуулгыг ариутган шүүсэн нь үнэ цэнтэй агаад жинтэй ажил болжээ.

Монголч эрдэмтдийн хурал, шашны олон улсын хурал, намын удаа дараагийн их, бага хуралд хэлмэрч, орчуулагчаар ажилласан нь 200 гаруйд хүрсэн бөгөөд тэрээр Монголын үе үеийн нэртэй орчуулагчдын нэгд зүй ёсоор багтдаг юм. Түүний эрдэм шинжилгээ, судалгаа, уран бүтээлийн санг сөхвөөс:

Өгүүлэл

1. “Үндэсний аюулгүй байдал ба соёл”, Стратегийн судалгааны хүрээлэнгийн сэтгүүл, 2001.
2. “Хүний Эш”, Нийгмийн ухааны түүхийн сэтгүүл, 2003.
3. “Буддын сурвалжийн уламжлал болон орчин үеийн орчуулгын тухай”, Энэтхэг Монголын сурвалж, соёлын хэлхээ холбоо, 2005.
4. “Англи хэлний угтвар түүний хэрэглээ”, ГХСС-ийн Соёл судлал сэтгүүл, 2004.
5. “Орчуулгын үг ба утга”, Гадаад хэл заах арга зүйн сэтгүүл, 2005.
6. “Орчуулгад үг оноох”, Нээлттэй нийгмийн хүрээлэн, 1999.
7. “Англи, монгол шүлгийн зарим онцлогийн тухай”, Яруу найргийн орчуулгын түлхүүр, Эрхэлсэн Г.Мэнд-Ооёо, Уб., 2006, 62-71 тал.
8. “Нууц товчооны зарим үг мөн хэлний тухай монгол англи орчуулгын тухай”, МУИС-ийн ОУХ-ны сургуулийн хэвлэл, 2006.
9. “Буруу орчуулахад булай тарина”, Орчуулгын онол, 2009.
10. “Үсэг товчилж, үг хураахуй хэмээх”, “Монгол судлал” Эрдэм шинжилгээний бичиг, Боть XXVII (285), Уб., 2007, 48-50 тал.

Толь бичиг

1. “Англи-Монгол, Монгол-Англи мал аж ахуйн дүймэн” Уб., 1999.
2. “Монгол-Англи буддын дүймэн”, Mongolian-English Buddhist glossary, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, Уб., 2006.
3. “Англи Монгол утга зохиолын дүймэн”, English Mongolian Literary glossary, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, Уб., 2007.
4. “Нууц товчооны хоёр мянга шахам үгсийн Монгол тайлбар ба англи үгийн хадмал”, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, Уб., 2007.
5. “Монгол- англи зүйлчилсэн толь”, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, Уб., 2008.

Англи хэлнээс монгол хэлнээ орчуулсан ном

1. “Бурхан багшийн сургааль Дармапада” Уб.,
2. “Түвдийн Буддын ертөнц 14-р далай лам” Уб.,
3. “Тунгаамал алт 3-р Далай лам” Уб.,
4. “Америк өгүүллэгийн цомирлог”, Мон Судар, Уб.,2010.

Монгол хэлнээс англи хэлнээ орчуулсан бүтээл

1. “Монголын нууц товчоо” З.Эрэндоогийн хамт, Уб., 2008.
2. Монголын яруу ном /Mongolian Literature/, Монголын зохиолчдын эвлэл, Уб., 2005.
3. “Баруун монголчуудын соёлын дурсгалт зүйл”, Монсудар, Уб., 2000.
4. “Монгол үндэстний биет бус соёлын өв”, Уб., 2010.

Редакторласан ном

1. “ Ухаант ардын өв”, О.Адъяа, 2007.
2. “ Англи хэлний өөрөө сурах”, Ц.Тэрбиш, 2005.
3. “Англи-орос-монгол өвөрмөц хэллэгийн товч толь”, 2006.
4. “ Эрдэнэсийн сангийн үнэт зүйл”, Улсын банк.
5. “ Зовлон жаргал”, тууж, Л.Зундуй.
6. “ Англи монгол үйл үгийн хэвшмэл хэллэгийн толь”, Т.Дүгэрээ, 2002.
7. “ Англи орос- монгол зүйр цэцэн үг хэллэгийн толь”, Т.Дүгэрээ, 2009.
8. “ Хэнтий нутгаар аялахуй”, 2005.

зэрэг болно.

“Монголын Нууц Товчоон”-ы англи орчуулга

Аливаа улс үндэстний уран зохиолын сор болсон бүтээлийг өөр нэг үндэстний хэлээр орчуулах нь тухайн ард түмний хэл, түүх, соёл, уламжлал, зан заншил, амьдралын хэв маяг, сэтгэхүйн онцлогийг таниулах цонх болдог. Монголчуудын хэл, түүх, соёлын үнэ цэнэтэй, 13-р зууны монголын уран зохиолын гайхамшигт дурсгал болох “Монголын Нууц Товчоон” бүтээлийг дэлхийн 21 хэлээр орчуулан, 130 гаруй удаа хэвлэн гаргаж олны хүртээл болгожээ.

2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан МНТ зохиолыг монголын эрдэмтэн орчуулагчид анхлан англи хэлээр орчуулан “*The Secret History of the Mongols*” нэртэйгээр хэвлүүлсэн бөгөөд эхний зургаан бүлгийг Н.Доржготов, сүүлийн зургаан бүлгийг З.Эрэндоо нар орчуулж, академич Д.Төмөртогоо хянан шүүж олны хүртээл болгосон. Н.Доржготов “МНТ зохиолд байгаа үлэмж хэмжээний үгийн утга хувиран өөрчлөгдсөн

байна ... надад эртний утга нь юу юунаас илүү чухал байлаа”¹⁶⁴ гэсэн байхад, З.Эрэндоо “Бидний орчуулга сонгомол эхтэйгээ аль болох ойр байхын зэрэгцээгээр өргөн олон нийтэд нэн ойлгомжтой байх шаардлагатайг их анхаарсан”¹⁶⁵ гэсэн нь зохиол дахь хэлц хэллэгийн утгыг нь сайтар гаргах, уншигчаа бодох гэсэн хоёр зарчмыг харгалзаж үзсэн нь ажиглагдаж байна.

МНТ-ны англи бүрэн орчуулгуудад, тухайлбал, К.В.Сун, Пол Каны орчуулгад зарим үг, хэлцийн салаа олон утга, шилжмэл утга, зүйрлэл утгыг анзаарч үзэлгүй ташаа орчуулах улмаар орхин орчуулсан байх нь цөөнгүй байгааг судалгаагаар тогтоолоо.¹⁶⁶ Харин Н.Доржготов, З.Эрэндоо нар МНТ-ны хөрвүүлэг болон өмнөх орчуулгуудыг харьцуулан үзэж өөрийн эх хэлнээсээ англи хэлнээ орчуулсан гэдгээрээ онцлогтой бөгөөд өвөрмөц хэлц, үг хэллэгийг хэрхэн орчуулсан нь сонирхолтой байгаа юм. МНТ-ны 200-аад хэлц хэллэгийг түүн авч Н.Доржготов, З.Эрэндоо нарын орчуулгыг хажууд нь хадан ажиглавал чамгүй сайн орчуулга болсон байх бөгөөд ялангуяа гадны орчуулагчдын гаргаж чадаагүй үндэстний онцлог бүхий үг хэллэг, хэлц хэллэгийн нарийн утгыг оновчтой зөв орчуулсан нь бахархууштай. Эдгээрээс зарим жишээг дурдвал:

➤ МНТ-ны 6-р зүйлийн ... *харуутай тэрэгний өлжигт* хэмээх хэлцийг **В.К.Сун:** In front of a *black cart* among that troop of people coming up is a beautiful girl. (Хар тэрэгний урд талд ...)

Ф.В.Кливез: At the forefront of one *black cart* ... (хар тэрэгний урд талд ...)

Пол Кан: In the middle of a band of people I see coming this way, at the front of a *black cart*, (хар тэрэгний урд талд ...)

Ө. Онон: He said: ‘Among those people moving camp towards us is a beautiful girl in the front seat of a *black-covered wooden cart*. (Хар бүрхүүлтэй модон тэрэгний урд суудалд ...)

И. де Рахивельз: There is a fine girl in the front seat of a *black covered cart*. (Хар бүрхүүлтэй тэрэгний урд суудалд ...)

Н.Доржготов, З.Эрэндоо: Duwa-soqur said, “There is a beautiful maiden sitting in the seat of *the covered carriage* drawn by an ox.

(Шар үхэрт хөллөсөн бүрхүүлтэй тэргэнд суугаа ...) гэж тус тус орчуулжээ.

¹⁶⁴ Н.Доржготов (2007) *Нууц товчооны хоёр мянга шахам үгсийн Монгол тайлбар ба англи үгийн хадмал*, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, УБ., 3 тал.

¹⁶⁵ З.Эрэндоо (2006) *Монголын нууц товчооны зарим үг хэллэгийн талаар*. “МНТ-ны гадаад орчуулга” сэдэвт ЭШХ-ын эмхэтгэл, УБ.

¹⁶⁶ Д.Отгонтуяа (2015) *Монголын Нууц Товчооны англи орчуулгыг задлан шинжлэх нь*, диссертацийн ажил.

‘Харуутай’ хэмээх үг нь ‘хараа саравч бүхий бүрхүүлтэй тэрэг’¹⁶⁷ гэсэн утгатай, харин *хар* гэсэн өнгийг зааж буй хэрэг огт биш юм. Орчуулагч Н.Доржготов утгыг нь мөшгин ухаж өмнөх орчуулагчдын “хар тэрэг” хэмээн ташаа орчуулсныг залруулан “бүрхүүлтэй тэрэг” хэмээн орчуулсан нь оновчтой болжээ.

➤ МНТ-ны 13-р зүйлийн **Нөхөр, шорлогд!** хэмээх хэлцийг

В.К.Сун: Dobun Mirgan asked him for a venison. (Добун Мэргэн түүнд бугын мах өгөхийг хүсэв)

Ф.В.Кливез: Companion, [give unto me of thy] roasted flesh. (Андаа, шарсан махнаасаа надад өгөөч)

Пол Кан: My friend, give me the meat that you’re cooking (Найзаа, чанаж байгаа махнаасаа надад өгөөч)

Ө.Онон: Friend, give me some of the meat, as my share.’ (Андаа, надад махнаасаа хэсгийг өгөөч)

И.де Рахивельз: ‘Friend, share the quarry!’ * *Lit., ‘Friend, the roast!

(Андаа, ангийн олзноосоо хуваалцаач) (Андаа шарсан махнаасаа хэсгийг өгөөч!)

Н.Доржготов, З.Эрэндоо: “Dear fellow, let us share a slice of good luck” (Хүндэт анд минь, аз хиймориосоо хэсгийг хуваалцаач)

гэж тус тус орчуулснаас үзвэл Н.Доржготов, З.Эрэндоо нар энэхүү хэлцийг монголчуудын ан агнуурын зан үйлтэй холбож задалсан нь илүү зөв орчуулга болжээ. Тэр тусмаа монголчуудын ан агнах ёсонд “мөч махаар жич хуваах” буюу ангийн олз хишгээсээ тохиолдсон хүмүүстэй заавал хуваалцах зан заншил байдаг ба тэр утгыг монголчуудын аз хийморийн ойлголттой холбож өгсөн нь сурвалж хэлний соёлын хам бичвэрийг илэрхийлэн гаргасан орчуулга болсон байна.

➤ МНТ-ны 21-р зүйлийн **Гарахдаа, наран сарны хилээр шар нохой мэт шазвалзаж гарах бүлгээ** хэмээх хэлцийн ‘шазвалзаж’ гэсэн үгийг

В.К.Сун: When he left, he climbed out *like a swift yellow dog* and disappeared on the rays of the sun or the moon.

(Тэрээр нар сарны туяагаар замхарч, *яарсан шар нохой шиг авиран гарав.*)

Ф.В.Кливез: When he went out, *like a yellow dog he was wont to crawl out* by the beams of the sun or moon.

¹⁶⁷ Ш.Чоймаа (2011) *Монголын Нууц Товчоо: Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг*, Уб., 9 тал.

(Тэр гарахдаа, нар сарны туяагаар *мөлхөн гарч дадсан шар нохой шиг* гарав.)

Пол Кан: Then he'd leave me, crawling out on the sunbeams or the shafts of moonlight, *crawling up like a dog as yellow as the sun.*

(Тэрээр намайг орхин явахдаа нарны туяанд эсвэл сарны гэрэлд *нар мэт шар нохой шиг* мөлхөн одов.)

Ө.Онон: He (slunk) *sheepishly away like a yellow dog* by the light of the sun and moon.

(Тэр нар сарны гэрлээр *шар нохой мэт айн/номхноор* гэтэн гарав)

И.де Рахевильц: When he departed, he crept out on a moonbeam or a ray of sun in the guise of a yellow dog.

(Тэр явахдаа, нар сарны туяагаар шар нохойны дүр төрхтэйгөөр мөлхөн гарав.)

Н.Доржготов, З.Эрэндоо: He scampered *just like the guilty yellow dog wags its tail.*

(Тэр *гэмтэй шар нохой сүүлээ шарваж байгаа мэт* айн зугтав) хэмээн буулгасан байна.

Д.Цэрэнсодном тайлбарлахдаа: “Тэнгэр язгуурт эрхэм хүнээ шар нохойтой зүйрлэсэн нь санамсаргүй хэлсэн зүйл биш бөгөөд Хүннү, Хятан зэрэг эртний зарим монгол овог аймаг нохой тотемтой байсан гэдэгтэй холбоотой байж болно. Нүүдэлч малчин монголчуудын амьдралд эрт дээр цагаас нохой чухал үүрэгтэй байсан нь ардын аман зохиол хийгээд бичиг шастирт тэмдэглэгдсэн нь цөөнгүй буй. Шар нохойтой адилтгасан цэгээн шар хүн бол тэнгэр язгуурыг гэрлээр бэлгэдэн үзүүлсэн бол домгийн сэтгэлгээний нэгэн уран дүрслэл юм”. (Д.Цэрэнсодном 2000, 199) гэсэн байна.

Элдэндэй, Ардаажавын тайлбарласнаар “*шазвалзах*” гэдэг нь “*шарвалзах*” гэсэн үгийн эртний хэлбэр гэж үзвэл уг үг нь сүүлээ шарвалзуулан хөдөлгөх гэсэн утгыг заана гэжээ.

Дээрх орчуулгуудыг харьцуулбал, К.В.Сун *climbed out* – ‘*авиран*’, Ф.В.Кливез *crawl out* – ‘*мөлхөн*’, Пол Кан *crawling up* – ‘*мөлхөн*’, Ө.Онон *slunk away* – ‘*гэтэн*’, И.де Рахевильц *crept out* – ‘*мөлхөн*’, Н.Доржготов, З.Эрэндоо ‘*wags its tail* – “*сүүлээ хөдөлгөн*” гэж өөр өөр үгээр орчуулжээ. Эдгээр орчуулгаас сурвалж хэлний соёлын хам бичвэрийн үүргийг анхаарах нөхцөлд Н.Доржготов, З.Эрэндоо нарын орчуулгад “*нохой сүүлээ шарван гарах*” гэсэн нь монгол хүний сэтгэлгээгээр оновчтой тэмдэгжүүлэн орчуулсан байна.

- МНТ-ны 117-р зүйлийн *Дайр Усуны эвэрт үнэгэн цагааныг Тэмүүжинээ унуулав* хэмээх хэлцийг

К.В.Сун: ...*a white stallion with a horn on its head (?)* which he had taken from the Merkit, Dair Usun. (толгой дээрээ нэг эвэртэй цагаан азарга)

Ф.В.Кливец: He suffered to be ridden by Темьжин the *kid [coloured] white [horse] and which had a horn*, also of Dayir Usun. (нэг эвэртэй ишгэн цагаан [морь])

Пол Кан: Then he led out the *whitish-tan warhorse* of Dayir Usun and had Anda Temujin ride on it. (цайвар шарга дайны морь)

Ө.Онон: and also gave him Dayir-usun's *horse* to ride. *It was white [like] a kid and had a horn.* (ишиг шиг цагаан өнгөтэй, нэг эвэртэй морь)

И.де Рахивельз: he gave Темьжин for a mount *the kid-white horse with a horn*, also of Dayir Usun. (нэг эвэртэй ишгэн цагаан морь)

Н.Доржготов, З.Эрэндоо: he gave Темьжин to ride on *the inborn white horse with the tuft of hair between its ears* also of Dayir-usun.

(хоёр чихнийхээ хооронд туг үстэй төрөлхийн цагаан морь) гэсэн байдлаар буулгажээ.

Энэхүү ‘эвэрт үнэгэн цагаан’ хэмээх хэлцийн ‘үнэгэн цагаан’ гэдэг нь ‘ишгэн цагаан’¹⁶⁸ гэсэн үг юм. Гэхдээ одоогийн бидний малладаг ямааны төл болох ишигний цагаан зүстэй бус харин янгирын ишигний зүстэй зүйрлэн хэлжээ. Яагаад гэвэл янгирын ишиг ямааны ишиг шиг хар, бор, хөх гэх мэт олон зүстэй байдаггүй, бүгд цагаан зүстэй байдаг. Үүнийг Н.Доржготов, З.Эрэндоо нар ишиг шиг нялх багаасаа цагаан өнгөтэй хэмээн эндүү ойлгон ‘төрөлхийн цагаан морь’ хэмээн орчуулсан бололтой. Харин ‘эвэрт’ хэмээх үгийг бусад бүрэн орчуулгад ‘нэг эвэртэй [морь]’ гэж эндүү орчуулсан байхад Н.Доржготов, З.Эрэндоо нар ‘хоёр чихний хооронд туг үс’ хэмээн зөв тайлбарлан орчуулжээ.

Дүгнэн хэлэхэд Н.Доржготов нь монголчуудын соёл, шашин шүтлэг, аж ахуй, утга зохиолын гүнд нэвтрэн, тэдгээрийг англи хэлнээ тайлбарлан, дүйлгэн орчуулахад өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулсан монголын нэрт дуун хөрвүүлэгч, орчуулагч байсан юм. Тэрээр ‘Монголын Нууц Товчоо’-г англи хэлнээ орчуулсан анхны монгол орчуулагч болохын хувьд эл зохиолын хэлц хэллэг, үндэсний онцлог бүхий үг хэллэгийн утгыг олон бүтээлээс шүүн үзэж, оновчтой орчуулсан хэмээн үзэж байна.

¹⁶⁸ Ш.Чоймаа (2011) *Монголын Нууц Товчоо: Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг*, Уб., 66 тал.

Summary

This paper examines the works done by N.Dorjgovov and his translation of the *Secret History of the Mongols*. He was a famous translator and interpreter who devoted his researches and works to the Mongolian culture, religion, way of living and literature by explaining the culture-specific terms including words, expressions and idioms. As a primary historical and cultural monument of thirteenth-century Mongolian literature, translation of the SHM by N.Dorjgotov and Z.Erendo did well in keeping the cultural heritage as well concerning the target readers.

Ном зүй

Н.Доржготов (2007) *Нууц товчооны хоёр мянга шахам үгсийн Монгол тайлбар ба англи үгийн хадмал*, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар.

Д.Отгонтуяа (2015) *Монголын Нууц Товчооны англи орчуулгыг задлан шинжлэх нь*, диссертацийн ажил.

Д.Цэрэнсодном (2000) *Монголын нууц товчоо*. Улаанбаатар.

Ш.Чоймаа (2011) *Монголын Нууц Товчоо: Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг*, Улаанбаатар.

Элдэндэй, Ардажав (1986) *Монголын Нууц Товчооны сийрүүлэл тайлбар*, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

З.Эрэндоо (2006) *Монголын нууц товчооны зарим үг хэллэгийн талаар*. “МНТ-ны гадаад орчуулга” сэдэвт ЭШХ-ын эмхэтгэл, Улаанбаатар.

Cleaves, F.W. (1982) *The Secret History of the Mongols: For the First Time Done into English out of the Original Tongue and Provided with an Exegetical Commentary*. Harvard University Press.

Dorjgotov, N, Erendo, Z. (2006) *The Secret History of the Mongols*. Ulaanbatar.

Igor de Rachewiltz (2004) *The Secret History of the Mongols. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century*. BRILL.

Paul Kahn (1984) *The Secret History of the Mongols: The Origin of Chinghis Khan*. North Point Press. San Francisco.

Urgunge Onon (2001) *The Secret History of the Mongols. The Life and Times of Chinggis Khan*. London.

Wei Kwei Sun (1957) *The Secret History of the Mongol Dynasty (Yuan-Chao-Pi-Shi)*. Muslim University, Aligarh.